ЭРДЭНЭС ТАВАНТОЛГОЙ

ЭТТ

**ЭРДЭНЭС ТАВАНТОЛГОЙ ХУВЬЦААТ КОМПАНИ**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
1 дүгээр хороо, Жигжиджавын гудамж 8, Финанс төв
Утас: 7505-5555
И-мэйл: info@erdenestt.mn, Вэбсайт: www.ett.mn

2024.04.15 № 01/602

танай ______________-ны № ______________-т

# ТЕНДЕРТ ОРОЛЦОХЫГ СОНИРХОГЧ ЭТГЭЭДҮҮДЭД

"Эрдэнэс Тавантолгой" ХК-аас зарласан ЭТТХК/20240102089 дугаартай "Шилэн кабелийн дэд бүтэц байгуулах ажил"-ын гүйцэтгэгчийг сонгох тендер шалгаруулалтад тендерт оролцохыг сонирхогч этгээдээс ирүүлсэн тодруулгын хариуг хавсралтаар хүргүүлж байна.

Дэээрх тодруулга нь тендерийн баримт бичгийн салшгүй нэг хэсэг болно.

Хавсралт: 2 хуудас.

ЗАСГИЙН ГАЗРЫН
ОНЦГОЙ БҮРЭН
ЭРХТ ТӨЛӨӨЛӨГЧ Ж.ГАНБАТ

TAVAN
ЭРДЭНЭС ТАВАН ТОЛГОЙ ХК
ERDENES
УЛААНБААТАР ХОТ

1124050318

Тодруулгын хариу

| | |
|---|---|
| Тендерийн нэр | Шилэн кабелийн дэд бүтэц байгуулах ажил |
| Тендерийн дугаар | ЭТТХК/20240102089 |
| Тендер зарласан огноо | 2024 оны 03 дугаар сарын 29 |
| Тендер нээх огноо | 2024 оны 04 дүгээр сарын 22 |

<table>
<tr><th colspan="2">Тодруулга №1</th></tr>
<tr><th>Тодруулга</th><th>Хариу</th></tr>
<tr><td>“Шилэн кабелийн дэд бүтэц байгуулах ажил”-ийн гүйцэтгэгчийг сонгох тендер шалгаруулалтын баримт бичиг заасан ТШЗ 19.1 хүний нөөцийн Холбоо дохиолол, мэдээллийн технологийн мэргэшсэн инженер гэрээт ажилтан байж болох талаар тодруулга авах хүсэлтэй байна.<br><br>ТШЗ 19.1 Ажил гүйцэтгэх хүний нөөц хэдэн хувь нь гэрээт ажилтан байх боломжтой талаар<br><br>ТШЗ 19.2 Техникийн чадавх болон туршлагын шаардлагыг нотлох баримт бичиг: 1. Ажил гүйцэтгэх хүний нөөцийн шаардлагыг нотлох дараах баримт бичиг ирүүлнэ 1.4 . Инженер техникийн ажилтнууд нь тухайн аж ахуйн нэгжид ажилладаг үндсэн ажилчид байх ба даатгуулагчийн төрлийн код 01, 22 төлөгдсөн үндсэн ажилтан гэж үнэлгээнд харгалзан үзэхээр заасан байгаа бөгөөд Нийгмийн даатгалын шинэчилсэн хуулиар даатгуулагчийн төрлийн код 06002, 22001, 40001, 01001 болж өөрчлөгдсөн байгаа тул хуульд нийцүүлж өөрчилж өгнө үү.</td>
<td>Тендерийн баримт бичгийн тендерийн өгөгдлийн хүснэгтийн ТШЗ 19.1-д дараах өөрчлөлтийг оруулж байна. Үүнд:<br>1. Ажил гүйцэтгэх хүний нөөц: “Шаардана
<table>
<tr><th>№</th><th>Албан тушаал</th><th>Тоо</th><th>Мэргэжлээрэй ажилласан жилийн туршлага</th><th>Мэргэжил</th></tr>
<tr><td>1</td><td>Ерөнхий инженер</td><td>1</td><td>3 болон түүнээс дээш жил</td><td>Холбоо дохиолол, мэдээллийн технологийн инженер</td></tr>
<tr><td>2</td><td>Хөдөлмөр хамгааллын инженер</td><td>1</td><td>1 болон түүнээс дээш жил</td><td>Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахиун сургалтад хамрагдсан гэрчилгээтэй байна</td></tr>
</table>
Холбоо дохиолол, мэдээллийн технологийн инженер болон Хөдөлмөр хамгааллын инженер (Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн ажилтан) нь тухайн аж ахуйн нэгжид ажилладаг үндсэн ажилчид байх ба даатгуулагчийн төрлийн 01001, 22001 код төлөгдсөн үндсэн ажилтан гэж үнэлгээнд харгалзан үзнэ.</td></tr>
<tr><th colspan="2">Тодруулга №2</th></tr>
<tr><th>Тодруулга</th><th>Хариу</th></tr>
<tr><td>ТШЗ 19.3 Ажил гүйцэтгэх байгууллага нь дараах тусгай зөвшөөрөлтэй байна. - Харилцаа холбооны зохицуулах хороо "Б ангилал" Гадна холбооны кабель шугамын угсралт суурилуулалт, засвар үйлчилгээ үзүүлэх” тусгай зөвшөөрөлтэй байх гэж заасан байгаа бөгөөд Харилцаа холбооны зохицуулах хорооны А ангилал ”Мэдээлэл</td>
<td>Ажил гүйцэтгэх байгууллага нь дараах тусгай зөвшөөрөлтэй байна. Үүнд:<br>1. Харилцаа холбооны зохицуулах хорооноос олгодог "Б ангилал" Гадна холбооны кабель шугамын угсралт суурилуулалт, засвар үйлчилгээ үзүүлэх”;<br>2. Харилцаа холбооны зохицуулах хорооноос олгодог 9.12.харилцаа холбооны сүлжээ, дэд</td></tr>
</table>

| | |
|---|---|
| холбооны үндсэн сүлжээ, дэд бүтэц байгуулах, эзэмших ашиглах" гэсэн зөвшөөрөл дотор Б ангиллын ''Гадна холбооны кабель шугамын угсралт суурилуулалт, засвар үйлчилгээ үзүүлэх'' гэсэн тусгай зөвшөөрөл багтдаг тул А ангиллын тусгай зөвшөөрлөөр тендерт оролцох боломжтой талаар тодруулга гаргаж өгнө үү. | бүтцийн суурилуулалт, засвар үйлчилгээ эрхлэх.<br>Жич: Харилцаа холбооны зохицуулах хорооноос олгодог 9.11 болон А ангиллын тусгай зөвшөөрлийг үнэлгээнд харгалзан үзэхгүй болно. |